

ТӨВ АЗИЙН УУГУУЛ ОРШИН СУУГЧ УГСААТНУУДЫН ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ДИНАМИКИЙН ЗАРИМ АСУУДАЛД

*М Хурметхан**

Төв Азийн уугуул оршин суугч угсаатнуудын туулж өнгөрүүлсэн түүх нь баялаг, нарийн ээдрээтэй юм. Хуучин ертөнцийн оршин тогтносон түүхийн гол цөм, хосгүй чухал хэсэг нь Төв Азид оршин сууж ирсэн уугуул угсаатнуудын зуун зуун жилийн бие, оюуны хүч, олон гарваль, хэл, угсаатан, аймаг үндэстнүүдийн хувь тавилан шүргэлцэн огтлолцож байлаа. Төв Азийн нэн эртний болон дундад зууны оршин суугчдын тухай шинжлэх ухааны судалгаа хийгдэн, өрнө дорно дахинд судалгааны бүтээл олон хэлээр бичигдсэн нь хангалттай байдаг юм. Тус салбарт үе үеийн дорнодахинчдын их хөдөлмөрийн ачаар сак, хүннү, сяньби, жужан, усун, кангюй, кюше, динлин, ухухань, фуой, хөх түрэг, огуз, кимак, кипчак, уйгур, кырык аз, казах, монгол, татар, өзбек, манж, афган, төвд, тангад гэх мэт ард түмнүүдийн талаар олон тооны судалгааны бүтээл хэвлэгджээ.¹

Эдгээр бүтээлүүдэд Төв Азийн уугуул оршин суугчдын гарал үүсэл, түүх, антропологи, археологи, соёл, аж ахуй, төрийн уламжлал, түүхэн хувь заяа, тавиланг тусгажээ. Дундад Ази, Казахстан, Монгол, Дорнод Туркестан, Афганистан, Өмнөд, Дорнод Сибирийн угсаатны өөрчлөлт, тус нутгийн түүхийн аль нэг үед нутаглаж байсан аймгууд, ард түмнүүдийн гарал угсаа, түүх, соёлын тухай тодорхой, бодит түүхэн баримтанд тулгуурласан шинжлэх ухааны ойлголт нэгэнт бүрэлдэн тогтсон байна.

Хэдий тийм боловч, Төв Азийн хүрээнд хөрш угсаатнуудын өнгөрсөн түүхийн угсаатан-улс төр, нийгэм-соёлын амьдралын олон асуудал бүрэн төгс судлагдаагүй байна. Тухайлбал: Төв Азийн хүрээнд хөрш зэргэлдээ ард түмнүүдийн угсаатан-нутаг дэвсгэр, гарваль угсааны хамаарал гэх мэт асуудлын хувьд эрдэмтдийн эсрэг тэсрэг байр суурь олонтаа тохиолдоно. Энэ нь Төв Азид орон зай, цаг хугацааны хувьд угсаатан, түүнийг түшиглэн төр улсууд үүсэн бий болж, хөгжлийн оргилдоо хүрч хөгжих, сулран доройтох, мөхөх, бие биедээ уусан шингэх зэрэг өөр хоорондын хийгээд байгаль нийгмийн харилцааны түүхэн мэдээллийн асар их ул мөр хадгалагдаж ирсэнтэй шууд холбоотойгоор урган гарсан гэж үзэж байна.

Төв Азийн ард түмэн өөрсдийнхээ түүхэнд тоо томшгүй дайн байлдаан, угсаатан-нутгийн хилийн маргаантай нутгаа булаацалдах, экологи-аж ахуйн шалтгааны улмаас нүүдэл-суудал хийх зэрэг үед угсаатан-газар нутгийн хил, угсааны бүрэлдэхүүн өөр өөр угсаатан

* М.Хурметхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

болон төрийн нэгдлүүд үүсэн бий болдог байлаа. Тэгээд ч иймэрхүү угсаатны өөрчлөлт хувиралтууд Төв Азийн эртний, дундад зууны оршин суугчид, овог, аймаг, ард түмнүүдэд бүрэн хамаарах билээ.

Эрдэмтдийн судалснаар МЭӨ 1 мянган жилд Дундад Ази, Казахстан, Дорнод Туркестаны нутагт эртний сак аймаг нутаглаж байсан нь тодорхой болжээ. Тэднийг Грекийн түүхч Страбон “Азийн скиф” хэмээн нэрлэсэн байдаг. Сакууд –хаумавар, тиграхау (шовгор оройт), тьяй-парадарая (тэнгисийн цаадах), хэмээн хуваагдаж байлаа. Тэдний холбоонд яксарт, массгет, исседон, дай, астак, камах аримас зэрэг эртний аймгууд нэгдсэн байжээ. Тэд соёлтой аймаг байсан бөгөөд соёлын дурсгал нь өнөөгийн Монголоос Унгар хүртэлх нутгаас олдсон байлаа. Археологийн судалгаа нь сак, массгет, скиф, дахчуудын материаллаг соёл адил төстэйг нотолжээ.²

Төв Азид амьдарч байсан Ди зэрэг монголжуу овог аймгууд, түрэг, монгол, манж тунгус угсааны овгуудын өвөг дээдэс байсан хийгээд дунд чулуун зэвсгийн үе буюу 12-7 мянган жилийн өмнөөс зэрлэг хонь, ямааг гаршуулж мал адгуулан амьдрах болсон тэр үеэс нилээд хожуу монгол, түрэг, манж-тунгус хэлний ялгаа гарчээ. Мөн хяньюнь, хяньюй, жүн, гүй, ху, дунху, сиху, хүннү зэрэг овог аймгууд байжээ. Тэдгээр аймгууд нэг төрөл байгаагүй бөгөөд, тухайлбал, жүн нарын бүрэлдэхүүнд нь төвд, тангад, иран, түрэг, манж-тунгус угсаатан мөн орж байжээ. Дуньхуаны нутгаас хойш зүүн, Дорнод Туркестаны хойд хилээр иран хэлт юэчжи аймаг байв. Динлин нар цагаан арьстан, европжуу хүмүүс байж одоогийн Монгол-Тувагийн хил орчим аж төрж байжээ. Ди аймаг бүхэлдээ Монголд амьдарч байсан гэж үздэг байна. Харин МЭӨ 3 мянган жилийн дунд үеэс эртний хяньюнь, хяньюй, гүй гэх мэт хүн, ху хэмээх үгийн хувилбар байж болзошгүй гэж үздэг.³

Хүннү нар бол Түрэгийн хаант улсаас өмнө Төв Азийн ихэнх нутгийг эзлэн аж төрж байсан хүчирхэг аймаг байв. Эрдэмтэд хүннү бол сак, усун, кангой нартай гарвал нэгтэй, эртний аймгуудын дундаас хамгийн их нэрд гарсан, хамгийн их тархсан аймаг болохыг тэмдэглэдэг. Хүннү нар МЭӨ 1 мянган жилд Монголын өмнөд талын Ордосоос Каспийн тэнгис хүртэлх Төв Азийн өргөн уудам нутагт оршин сууж байсан гарал үүсэл, угсаатны хувьд янз бүр байжээ. Улмаар аж ахуй хөгжиж, ахуйн нилээд төстэй байдал, улс төрийн дэглэмийн хүчин зүйл нь Төв Азийн эртний нэгдмэл томоохон аймгийн холбоо бүрэлдэж бий болоход хүргэв. Хүннү нар өмнөд, умард хоёр хэсгээс бүрджээ. Умард Хүннү нарын бүрэлдэхүүнд Онон, Хэрлэн мөрнөөр нутагтай сяньби болон ухуань аймаг ордог байлаа. Хүннүгийн Модун Шаньюйгийн үед юэчжи аймгийг эзлэн, тэр үедээ одоогийн Солонгосоос Төвд хүртэл, Дорнод Туркестанаас Хуанхэгийн дунд урсгал хүртэлх нутаг хүннүгийн эзэмшилд байхын хамт, хойт талдаа Байгаль нуураас цаадах нутгийг

оршин суугчид Хүннүгийн бүрэлдэхүүнд байлаа. Хүннүгийн дундаас Хуянь, лань, суйбу, люантинь гэсэн дөрвөн овог тодрон гарчээ. Өмнөд Хүннү Ордос нутгийг, умард Хүннү Саян, Байгаль нуураас Цагаан хэрэм хүртэлх нутгийг эзэмшиж байв.⁴ Хүннү улс (МЭӨ 3 зуунаас МЭ 2 зуун) 300 орчим жил оршин тогтнов.

Хүннү улсын бүрэлдэхүүнд монгол, түрэг, хамниган нараас гадна бусад угсаатан багтаж байсан нь маргаангүй байв. Улмаар Хүннүгийн хүн ам нь байсан газартаа угсаа гарвалын хэд хэдэн голомт үүсгэн нэгтгэлжин тоо цөөрсөөр ирсэн ба өөр хоорондоо болон хөрш угсаатнуудтай холилдох замаар үлдсэн хүн ам нь хожмын Төв Азийн бараг бүх угсаатан бүрэлдэх цөм нь болон оролцжээ⁵.

Усун нар Төв Азид аж төрж байсан өөр нэг эртний аймаг. Усун нар Илийн хөндий хавьд нутаглаж байжээ. Тэдний угсаатан-улс төрийн түүх нь бүрэн судлагдаагүй байна. Усун нарын тухай анхны мэдээ МЭӨ 2 зууны сүүл үед хамаарагдаж байгаа юм. Баруун улсуудад ирсэн Хятадын элч Чжан Цяний мэдээлсэнээр усун нарын дунд сак, юэчжи угсаатны хэсэг байгааг заажээ⁶.

МЭӨ 2 зууны хоёрдугаар хагаст “ард түмнүүдийн их нүүдэл” гэж нэрлэгдсэн экологи-түүхэн үйл явц Төв Азийн угсаатнуудын нутаг дэвсгэр, хүн амын бүтэц, байршилд ихээхэн өөрчлөлт оруулсан байна. Их нүүдэл дууссанаар оршин суугчид дахин нэгтгэлжин шинэ угсаатны нэгдэл, төр улс үүсэх урьдчилсан нөхцөлтэй болсон байна. Түүний үр дүнд усун, янчай, хангюй тодрон гарчээ.⁷

МЭ 1 зуунаас Сяньби аймаг Төв Азийн түүхэнд мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэж эхэлжээ. Тэд Дорнод Хугийн хойшис болов. Таньшихуаны үед Хүннү нар хүчирхэг байх үедээ эзэлж байсан бүх нутаг дэвсгэрийг эзэгнэн Төв Азид ноёрхов.⁸

Их говийн өмнө зүг нутаглаж байсан жужан хэмээх нүүдэлчин аймгийн тухай мэдээ анхан МЭ 4 зууны үед хамаарагдана. Жужаны хаадын орд Хангайн уулсад байрлаж байлаа. Жужан нар Сяньбигийн ноёрхлоос 5 зуунд гарчээ. Жужаны хаант улс нь Шелунь хааны үед олон олон аймгийг номхотгон захирав. Хятадын эсрэг байнга довтолж байв. Усун нарыг Долоо-Уснаас Памир, Тэнгэр уул руу шахаж, уйгуруудтай байлдав. Тэд 4 зууны сүүлээс 6-р зууны дунд үе хүртэл Төв Азид томоохон үүрэг гүйцэтгэв. Улмаар 6-р зууны дунд үед түрэг аймгуудын довтолгооноос жужаны холбоо задрав.⁹

552 онд түрэг аймгууд жужаны хаант улсыг бут цохисны дараа Төв Азид Түрэгийн хаант улс байгуулагдав.¹⁰ МЭ 6 зууны 80-аад он болоход Түрэгийн хаант улс ихэд өргөжин, түүний бүрэлдэхүүн янз бүрийн овог, угсааны олон аймаг, ястан багтаж орсон байжээ. Тухайлбал, монгол нутагт хадгалагдсан түрэг бичээсийн дурсгалуудад тэр цагийн Төв Азийн угсаатнуудын тухай бодит мэдээлэл хадгалагдан

үлджээ. Түүнд тэмдэглэснээр он ок будун, ашина, хөх түрэг, аштаг, басмыл, табгаш (хятад), татабы, чик, төвд, кырык аз, согд, китан, байыргу, он ок, тат, авар, рим, уч куркан, талис, бухар, бершекер, тардуш, түркеш, карлук, уч огуз, курдан, тогуз-огуз, огуз, тогуз-татар, тангад, алты чуб, он тутых, изгил, едиз, тонгира, эфтал, цөлийн аз, архай зэрэг овог, аймаг, ард түмнүүд зүүн Түрэгийн хаант улсад болон хөрш зэргэлдээ оршин байжээ.¹¹

Татабы (уйгур-төвдээр – дад-т, кумохи, араб, персээр хий) эртний монгол аймаг, анхандаа монголын дорнод талаар, нэг хэсэг нь Манжуураар нутагтай байв. Түүхэн сурвалжид тэмдэглэснээр татабы, нар МЭ 220 оноос түүхэнд тодорхой юм. Хятадын түрэмгийлэгчдийн эсрэг өөрийн хөрш кидан болон түрэгүүдтэй холбоо байгуулан, 696 онд Хятадуудын цэргийг хиар цохижээ. 845 онд Хөх Түрэгийн Холбооны /Уйгурын/ хаант улс мөхсөний дараа тэдний нэг хэсэг нь Монголын хойт хэсэг рүү нүүн орж, тэнд үлдсэн уйгур болон түрэг аймгуудтай нэгджээ. 10-р зуунд татабы нарын нэг хэсэг нь Хай гэдэг нэрээр Алтай болон Эрчис мөрнөөр нутаглаж байсан ажээ. Харин 11 зуунд тэд кимакуудын бүрэлдэхүнд орсон тухай мэдээ байдаг.

Авар түрэг хэлтэн аймгийн том холбоо, 5 зуунаас тодорхой болжээ. Авар нар Төв Азиас Европт нүүн очиж, баруун Түрэгийн хаант улсыг байгуулсан аймгуудын үндэс байлаа. 6 зуунд тэд баруун Каспий, Хар тэнгисийн хойт хэсэг, Дунай, Балхашийг эзлэн авч, Европын хэд хэдэн аймгийг захирав. Бие даасан төр улс Аварын хаант улсыг байгуулан, слав, франк, лангобард, гүрж, византийн нутагт довтолж байлаа. 8 зууны 90-ээд онд Их Карлын франкууд тэднийг мөхөөв.

Басмыл эртний түрэг аймаг, 7 зуунаас эхлэн үндсэн нутаг нь Алтайд байв. 651 онд Зайсан нуурын хойт, Енисейн киргисийн баруун өмнөд, Тарвагатай уулын хормойд тархай нутаглаж байжээ. Тэднийг Махмуд Кашгари түрэгийн хойт хэсгийн аймагт багтаажээ. Энэ бүлэгт Саян-Алтайн Кипчаг, огуз, йемек, башкурт, хай, йабаху, татар, киргис багтана. Хай, йабаху, татар болон басмыл хэлийг задлан шинжлээд М.Кашгари “Тэд өөрсдийн хэлтэй, гэвч түрэгээр сайн мэддэг” гэжээ. 744 онд Зүүн Түрэгийн хаант улсыг мөхсөний дараа тэд Орхоны хөндийд ирж суурьшив. Басмылийн нэг хэсэг тэр үед Монголын өмнөд хэсгээр нутаглаж байжээ. 8 зууны дунд уйгур карлукуудад ялагдсаны дараа басмыл 5 жижиг хэсэгт хуваагдав. Тэдний дунд киштым, адкаш, изгил нэр байна.

Байырху (эртний түрэг аймаг) 5 зуунд Теле аймгийн холбоонд, дараа нь Түрэг, Түрэгийн Холбоо /Уйгурын/ хаант улсын бүрэлдэхүүнд байв. Байырху нар түрэгийн умард хойт талаараа Байгаль нуураас Саяны нуруу хооронд оршиж байв. Тэдний суугуул нутаг – Байырху буюу Баружин (Баргужин) голын хөндий юм. 8 зууны эхэнд тэд 2-р Түрэгийн хаант улсын эсрэг удаа дараа тэмцэж байв. Энэ үед Байырху

нарын хүн ам 60 мянган хүн байлаа. Байырху аймгийн олонхи хүчирхэг Мэргид аймгийн бүрэлдэхүүнд орж, Мэргэдийн түүхийг бүтээв.¹²

Согд (Согуд, Согдина) – Зеревшан, Кашкадарья голын хөндийд одоогийн Өзбек, Тажикстанд оршиж байсан эртний төр улс. Нийслэл нь Мараканд (Самаркан) байв. МЭӨ 6-4 зуунд Персийн Акеман улсын бүрэлдэхүүнд байв. Согдыг 4-5 зуунд эфталитууд (цагаан хүннү), 6-7-р зуунд түрэгүүд, 8 зуунд арабууд эзлэв. Монгол болон Хятадаас Мерв хүртэл торгоны замын дагуу согд нарын худалдаа-тариалангийн суурингууд байлаа. Согд нар хамит-семит, аремей бичгийг хэрэглэж, энэтхэг-европ хэлний дорнод бүлэг иран хэлээр ярилцаж байв. Согд хэл МЭӨ 1 зуунаас –МЭ 9-р зуунд байсан хэл юм. Согд бичиг нь маш эртний, шинэ гэсэн хоёр төрөл бөгөөд, уйгуржин бичиг (худам), манж бичгийн үндэс болжээ.¹³

Тардуш-Зүүн Түрэгийн хаант улсын нэг хэсэг. Аймгуудын газар зүйн шинжээс улбаалан цэрэг-засаг захиргааны хоёр холбоо байв. Тэд Тардуш хаант улсын баруун хэсгийг болон телесчууд дорнод хэсэгт нутагладаг аймгууд байв.

Аз-Долоон Ус дахь Туркешийн бүрэлдэхүүнд ордог түрэг хэлтэн аймаг. 8-р зууны 1-р хагасад Зүүн түрэгүүдийн Болучу голд турхануудтай хийсэн байлдааны тухай мэдээ байна. Күлтегиний бичээст туркешүүдийг ялсны дараа Аз нар Табары хавьд (Илийн хөндий) нутагласан тухай мэдээ бий. 11-р зуунд амьдарч байсан түүхч Гардизи Туркешүүдийг хоёр хэсэгт хуваадаг бөгөөд нэг нь тухси, хоёр дахь нь Илийн хөндийг нутагласан Аз гэжээ. 7-р зуунд бичигдсэн зохиолуудад Азыг–Азгыр гэдэг. Азгыр долоон ус дахь “он ок” Түрэгийн бүрэлдэхүүнд байсан гол аймгийн нэг гэдэг. Ибн Хордадбе (9 зуун), Идириси (1099-1165)-ын бичсэн азкиш (аз + киш: цөөн хүмүүс) нь Аз угсаатны нэрийн нэг хэлбэр юм. Идириси эднийг Эрчисийн Кимакуудын нэг адил, эрүү, толгойн яс том, үс нь өтгөн, нүд нь хурц, хэл нь бусад түрэгүүдээс өвөрмөц, гал болон гялалзсан бүхэнд залбирдаг гэжээ. Махмуд Кашгарийн үед (11 зуун) азкиш нар Ферган, Уздендээр нутагтай байлаа.

Аз-2. Енисейн дагуу нутагласан түрэг аймгийн нэр. Энэ тухай анхны мэдээ зүүн түрэгийн цэргийн ангиуд Ана голын дагуу Кырык Азийн нутагт хийсэн дайралтын тухай мэдээнд гардаг. Дөрвөн Аз хэмээх овог алтайчуудад одоо ч гэсэн байдаг.

Эфтал. (хионит цагаан хүннү), 3-6-р зуунд Төв Азид төр улсаа байгуулсан угсаатан юм. 457 оноос эфталитуудын тухай тэмдэглэгдсэн ба тэд Согд, Мерв, Кабул, Пенджаб, Кашгар, Кучан, Хотаныг эзэлж, Дундад Ази, Зүүн Иран, Хойт Энэтхэг, Дорнод Туркестаныг нэгэн төр улсад нэгтгэжээ. 6-р зууны 2 хагасаас түрэг болон эфталитуудын хооронд хүчтэй мөргөлдөөн эхэлжээ. 563-567 онд Истеми хаан Ирантай холбоо байгуулан Эфталитийн улсыг мөхөөв. Ташкент дахь

Топрахкала, Варахша дахь хааны ордны үлдэгдэл (Бухараагаас 35км) эфталитийн үеийн дурсгал юм.

Кидан. Монгол хэлтэн аймаг¹⁴ Монголд МЭ 4-р зуунаас нутаглаж байв. 907 онд аймгийн зонхилгогч Ила-Абучи өөрийгөө Киданы эзэн хаан хэмээн зарлав. Тэрбээр хөрш аймгуудыг нэгтгэн, дорно зүгт Бохайн хаант улсыг эзлэв. Японы тэнгисээс Туркестан хүртэлх нутгийг эзэлсэн Ляо улс Зүүн хойт Ази дахь маш хүчирхэг улс байв. 1005 онд Хятад Кидануудтай байлдан ялагдаж, жил бүр татвар төлөх болжээ. 11-р зууны сүүлээс тэдний төр улс доройтож, 1125 онд Зүрчид нарт мөхөөгдөв. Киданы үед Түрэг аймгууд Зү Бү гэдэг ерөнхий нэрийн дор 20 гаруй аймаг байжээ. Умард Зү Бү гэдэгт Керей, баруун Зү Бүд Найман нарыг нэрлэжээ. 1089 онд Керейн Маркус Зү Бү аймгийг толгойлох болов. Кидануудын нэг хэсэг нь Төв Азид нүүн ирж суурьшин, Харакидан (Хараханид) улсыг байгуулав. 11-р зуунд Долоон Усад кидануудын хүн ам 40.000 өрх байв. Тэд 1137 онд Самаркан, Бухар, Хорезмын хотуудыг булаан эзлэв. Тэд улмаар орон нутгийн түрэг хэлтэн ард түмэнд (казах, киргиз, каракалпах) уусчээ. Хараханид улс нь Дорнод Казахстан болон Дундад Азид 1140-1213 оны хооронд оршин тогтнов. 1137 онд Ходжентэд тэд Мауараннахрын захирагч Махмуд хааны цэргийг, 1141 онд салжикуудыг ялав. 1212 онд найманы Хүчлэг хаан өөрийн ноёрхлоо тогтоожээ. Улмаар Долоон Ус, Дорнод Туркестан, Алтайн уулсын нутгийг найманууд ноёрхов. Энэ нь удаагүй бөгөөд 1218 онд Чингэсийн цэрэг орж ирэв.

Түркеш. Алтай, Долоон Усыг нутагласан түрэг аймаг. Хятад, Араб, Персийн сурвалж бичигт тэмдэглэснээр 6-р зуунд байсан авар, муари аймгийн холбоо юм. 7-р зуунд Баруун Түрэгийн хаант улсын бүрэлдэхүүнд оров. 711 онд Зүүн Түрэгийн хаант улсын жанжин Култегинд ялагдаж, Түркешийн холбоо задрав. В.В.Бартольдын үзэж байгаагаар, түркеш-тохси, ази гэж хоёр хэсгээс бүрдэг байсан ба, аз нэрийг орхоны бичээст бичсэн байна. Түркеш нар Долоон Усад Түркешийн хаант улс (704-768) байгуулж байв. Тус бүр нь 7.000 хүнтэй, 20 тойргоос бүрдэж, 200.000 хүнтэй байжээ.

Тогуз-огуз. Эртний түрэг аймаг, 8-р зууны орхоны бичигт тодорхой тэмдэглэгджээ. Мөн Тогуз-огуз нарын тухай 630 онд Хятадын сурвалж бичигт тэмдэглэжээ. Энэхүү аймгийн холбооны үндсийг 9 аймаг (сеяньто, уйгур, пангу, пугу, тунло, хүн, хуеие, толанко, атие) байгуулав. Холбоог анх сеяньто тэргүүлж байсан бол, түүний дараа Зүүн Түрэгийн хаант улсыг эзэлж, 744-745 онд Монгол оронд Хөх Түрэгийн Холбоог /уйгурын хаант улс/ байгуулсан тогуз-огузууд удирдах болов. Холбооны хаант улс 90 жил оршин тогтнов. Энэ үед хот суурин, бичиг үсгийн соёл хөгжив. Тогуз-огуз нар хөрш Карлук, Енисейн Кырык Аз, Кидан, отыз-татаар, төвд гэх мэт угсаатантай

харилцаатай байв. 840-845 онд тэднийг Енисейн Кырык Аз нар довтлон мөхөөж, нэг хэсэг нь нутагтаа үлдэж нэг хэсэг нь Ганьсуд, нөгөө хэсэг нь Турфан (Дорнод Туркестан)-д шилжин суурьшив. Ганьсудахь Уйгурын хаант улсыг 1028-1038 онд тангад нар мөхөөв. Дорнод Туркестан дахь уйгурын төр улс 1250 онд тусгаар тогтнолоо алдав. Энд уйгурын ард түмний бүрэлдэн тогтох явцад тогуз-огуз нэр нь аажмаар мартагдан уйгур нэр дэлгэрэв.

Тогуз-уйгур. 7-р зууны дундаас тодорхой болсон эртний түрэг аймаг. Сэлэнгэ мөрнөөр нутагласан тогуз-огузын бүтэц байв. Эдгээр нь иолго буюу йаглагар, хүдүгэ буюу кадар, кюлоу буюу кутубур, аучжай буюу бэрсил, аучжай буюу айтаз, гэса буюу касар, хувынсо буюу хугузу, иовуга буюу тагаткар, бэди юм. Тогуз-Уйгурын йаглагар тэргүүлсэн “гадаад” бүтцэд саиг уйгуруудаас гадна бугут, хун, байырху, тонгра, сигир, кибир, басмыл, карлук нар хамаарагдаж байлаа. Тэдний овог аймгийн бүтэц, түүхэн үе шат болгонд харилцан адилгүй өөрчлөгдөж байжээ. Тогуз-огуз ба тогуз-уйгурын тодорхой нэг түүхэн үе дэх ялгааг тодорхойлох хэцүү. Рашид-Ад-Дин уйгурын нэг хэсгийг нөгөөгөөс ялгаж чадахгүй байсан бөгөөд, тэднийг нутгийн дагуу ангилж байлаа.

Тангад (минья) Одоогийн БНХАУ-ын Ганьсу, Шэнси мужид Си Ся улсыг байгуулж, оршиж байсан, өөрийн соёл бичиг үсэгтэй ард түмэн байв. 1227 онд Чингис хаан эзэлсэний дараа тэд Хятад, Төвд, Монголд уусчээ.

Отыз-Татар. Татар гэдэг нэр “Сүншү”-ийн 95-р бүлэгт “Жүй жүйн нэг нэр нь датань, бас тантань гэнэ. Мөн л хүннүгийн тусгай нэг аймаг” гэжээ. Культегиний бичээст татар хэмээх нэр отыз татар хэмээн тодорхой тэмдэглэгджээ. Г.Сүхбаатар энэ нэрээр дундад зууны монголчуудыг нэрлэж байсан ба 13-р зуунд Татар нэртэй аймаг жужаны шууд удам угсаа гэж үзсэн байдаг.¹⁵ Монгол нутагт 745-840 оны үед оршин тогтнож байсан Хөх Түрэгийн Холбооны улсын үед – яглакар, он уйгур, йаглагар, кадар, кутубур, бэрсил, айтаз, касар, хугузу, иаг, бэд, тыва, тогуз-уйгур (9 уйгур), Кырык Аз (40 Аз), карлук, чигил аймаг, түргеш, огуз, татар, согд, табгаш, кипчак зэрэг овог аймгийн талаар тодорхой тэмдэглэгджээ.

Махмуд Кашгари нь Төв Азийн бүх нутгийн ард түмнүүдийн талаар олон зүйлийн бичиг үлдээсэн байдаг бөгөөд, огуз, шигил, ягма, карлук, тухси, түркмен, Кырык Азийн талаар бичжээ. Энд дундад эртний үед аж төрж байсан огуз аймгийн тухай товч өгүүлбэр. Тэд Дунд Ази болон Төв Азид аж төрж байсан түрэг хэлтэн аймаг байв. 7-р зууны эхэнд Баруун Түрэгийн хаант улсын бүрэлдэхүүнд тогуз-огуз (9 огуз)-ын холбоо бий болжээ. Орхоны бичээст Зүүн Түрэгийн хаант улсад огуз аймаг орж, Дорнод Монголд нутагтайг тэмдэглэжээ. Гэвч Төв Ази, Дундад Ази, Казахстаны огузуудын угсаатны өөр хоорондын ах дүүгийн холбооны асуудал бүрэн тодорхой болоогүй. 9-р зуунд огузууд Дорнод

Туркестан, Ганьсуд нүүн очиж нутаглажээ. Энд тогуз-огуз гэдэг угсаатны нэр нь аажмаар уйгур хэмээн нэрлэгдэв. 9-10-р зуунд Өмнөд, Баруун Казахстанд огуз угсаатан аажмаар бүрэлдэн тогтов. Огуз нар хэд хэдэн аймаг, аймаг нь овгуудад хуваагдаж байв. Махмуд Кашгари огуз нар эхлээд 24 аймаг, сүүлд 22 аймаг болсон гэжээ. Тэд бузук (баруун гар), учук (зүүн гар) болж хуваагдан, улмаар кипик, байандур, ива, салур, афшар, бектили, букдуз, баяд, язгур, имур, харбулаг, алагбулаг, ичдыр, урегир, тутирха, ула-йондлуг, түгэр, тебни, бежене, жуылдыр гэх мэт байв. Огузын эдгээр аймгууд хожим нь казах, киргиз, татар, башхурт, түркмен, өзбек, каракалпах угсаатны нэгэн бүрэлдэхүүн хэсэг болон оролцов.¹⁶ Огузын холбоог дорно зүгээс ирсэн кипчаг нар мөхөөв.

Кипчаг. (куман, половцы)-казахын ард түмнийг бүрэлдүүлсэн эртний томоохон аймаг. Махмуд Кашгарийн тэмдэглэснээр, 9-р зуунд кипчагийн овог аймгийн бүтэц нь (тохсоба, йетиоба, бөритогли, елбөрли, кангарли, анджогли, дурут, кул, абогли, жартан, харабөрикли, хотан) байв. Кипчаг гэдэг нэр хятадын сурвалж бичигт (МЭӨ 201 он.)- кюеше, кипча, куча, хибиса гэх мэт тэмдэглэгджээ. Сэлэнгэ мөрнөөс олдсон түрэг бичээст (759 он) “түрэг Кипчаг” гэж нэрлэгдсэн тодорхой овгийн тухай мэдээ байна.

Карлукын хаант улс (766-940) оршин тогтносон. Долоон ус дахь эртний улс болно. 8-9-р зуунд энд чумук, улиг-ак, түркеш-калаш, сурниш, жабшид, азгир, кашу, барсхан гэх мэт аймгууд нутаглаж байв. Карлук нар гурван овгоос булат, жуз, ташлаг бүрджээ. Казахын Дунд жузийн өвөг дээдэс нь тэд байв. Птолемей (2-р зуун) карлук (carinae) бол Алтайд нутагладаг ард түмэн гэж тэмдэглэсэн байдаг. Тэд түрэг хэлтэн тирекчуудын (теле) нэг аймаг гэжээ.¹⁷

Кимак түрэг гарлын аймаг. Кимакуудын холбоо 9-р зууны 1-р хагаст бий болов.¹⁸ Түүний бүрэлдэхүүнд анхандаа 7 аймаг оров. Тэд эймур, имак, татар, баяндур, кипчаг, ланиказ, ажмад юм. Кипчагууд Кимакын баруун хэсгийг бүрдүүлэн 11-р зуун хүртэл тэдний бүрэлдэхүүнд байв. Кимакуудын тухай эртний мэдээ Гардизигийн (11-р зуун) хэлснээр 7-р зуунд хамаарагдана, газар нутаг нь баруун талдаа Сырдарияд нутагтай огуз нартай, зүүн талдаа карлуктай, Дорнод Туркестаны тогуз-огуз нартай, зүүн талдаа Енисейн хиргисүүд, хойт талдаа угор аймгуудтай хиллэж байв. 840 онд уйгурын хаант улс мөхсөний дараа түүний бүрэлдэхүүнд байсан эймур, баяндур, татар аймгууд түүнд нээгдэв.

11-р зууны эхээр Төв Азийн нүүдэлчин аймгууд хүннү, хай аймгийнхан тэдний нутгаар дамжин баруун зүг шилжсэн нь Кимакын улсыг мөхөхөд хүргэжээ. Кимакын орыг Кыпчаг аймаг эзлэв.

13-р зуунд зохиогдсон “Монголын Нууц товчоо”-нд Төв Ази түүний эргэн тойронд тухайн цаг үед аж төрж байсан овог, аймаг,

ард түмнүүдийн талаар тодорхой мэдээнүүд уламжлагдан иржээ. Үүнд: хорь түмд, урианхай, дөрвэд, жадиран, манан, баарин, хатагин, салжид, боржигин, барулас, будаад, урууд, мангуд, бэсүд, оронар, хонхотан, арулад, сонид, хабтурхас, хэнигис, журхи, айргууд, буйрууд, татар, олхуноуд, мэргид, хамаг монгол, тайчууд, хонгирад, сүлдүс, мэргэд, увас (ухаа) мэргэд, хаад мэргэд, жалайр, дархад, чаншиут, баяуд, мангуд, сүхэгэн, горлос, ихирэс, ноёхон, хэрэйд, турхин, найман, дөрвөн, ойрд, уйгур, тангад, сартуул, хятад, цагаан татар, алчи татар, тутанууд татар, алутай татар, убчигдай, алчидай, түмэн түбэгэн, олан дунгайд, хашин, онгуд, сүлдэй, хар хидан, канлы, кыпчаг, харлаг (харлук), буриад, барга., барга урсууд, хабханас, ханхас, туба, хиргис, ойн иргэн, хасаг, зүрчид, хар хятад, жуйн, халиф султан, индус, арумару, маусаары, бажгид, орос, мажар, асу, сасу, чэркес, кашмир, бол/г/ар, лала зэрэг овог, аймаг, ард түмний нэр байна.¹⁸ Эдгээрийн олонхи нь Төв Азийн монгол, түрэг, манж хэлтэн, овог, аймаг болохын хамтаар хятад, төвд, орос зэрэг бусад ард түмэн ч байна.

“Монголын Нууц Товчоо”-нд тэмдэглэгдсэн зарим томоохон аймгийн талаар товч өгүүлэе.

Хамаг Монгол.²⁰ Рашид-Ад-Дин “Судрын чуулган” гэдэг зохиолдоо дурдсанаар 1390 оноос 2000-аад жилийн тэртээ монгол аймгийн өвөг дээдэс бусад аймагт хядуулахад зөвхөн хиян, нукуз хэмээх хоёрхон овог үлдээд Эргүнэ Кун гэдэг газар очиж суужээ. Эргүнэ Кунд 400 жил нутаглаж суухад хүн ам өсч -нукуз, уранхайд, хонгирад, ихрэс, олхонуд, елжиган, арулат, сүлдэс, баяуд зэрэг 20 гаруй овог үүссэн хэмээн Рашид-ад-дин бичсэн бол Лю Жэнсо Эргүнэ Кунаас гарч ирэхдээ 70 салбар овог болон өргөссөн бөгөөд тэд дарлигин монгол юм.²¹

Нирун Монгол бол Алунгоогийн ариун нуруунаас төрсөн тэнгэрийн хөвгүүдийн залгамж удам гэсэн утгатай ажээ. Алунгоогоос Хабул хааныг хүртэл нирун, Есүгей баатар хүртэл нирун хиад, Есүгей баатраас Чингис хаан тэргүүтэн болон түүний хөвгүүдийн удам угсааг хиад-боржигон хэмээн тус тус нэрлэдэг болжээ. Хотула хааны үед дарлигин 16 аймаг, нирун 16, жалайр, тайчууд аймаг байжээ.

Хамаг Монгол нь монгол үндэстний өвөг дээдэс болно. Эртний монгол угсаатны гарлын бүдүүвч дараах байдалтай юм. 11-12-р зуунд Төв Ази болон Монгол оронд Хамаг Монголчуудаас (гурван голын) гадна кидан, керей, найман, татар, онгуд зэрэг хүчирхэг аймгууд байв. Язгуурын монгол аймгууд нь 11-13-р зуунд Дэрлигин (нукуз, урианхай, хонгирад, ихэрис, олхонуд, куралис, илжигэн, килингут, кунжин, үшин, сүлдсүн, илдуркин, баяуд, кингит, кунглают, хонхотан, арулат) нирун (хатигин, салжуд, тайчууд, хартахан, сэжиут, чинус, ноёхон, уруд, мангуд, дөрвөн, баарин, барулас, кадархан, журияд, жадаран,

будаат, дуклад, бэсүд, куният, сухан гэсэн хоёр том хэсгээс бүрдэж байв.²² Тэд Онон, Хэрлэн, Туул голын эхээр нутаглаж байжээ.

Хиад Эртний монгол овог. Рашид-ад Диний тэмдэглэснээр хиад нь тайчуудаас гаралтай ажээ. Хиад нь хиад –иргэн, хиад-боржигон болох бөгөөд хиад-боржиганаас Чингис хаан гаралтай юм. Хиад овгийн ихэнх нь Чингис хааны баруун зүгт хийсэн аян дайнд оролцож, эзэлсэн орнуудын хүн ам дунд оршин суув. 15-16-р зуунд түрэгүүдийн дунд байсан монгол овгуудын нэг адил түрэгжин, өзбек, каракалпахын бүрэлдэхүүн болжээ. Монголд үлдсэн хэсэг нь түүхээ үргэлжлүүлэв.

Жалайр аймаг нь огузаас гаралтай ажээ. Жалайр огузын дулу, чумугун аймгийн хамтаар түүний хаант улсын бүрэлдэхүүнд оров. Монголын эзэнт гүрний үед жалайр аймаг Онон голын хөндийд байсан. Төв Азид чухал үүрэг гүйцэтгэгдэхэд оролцов.²³ Рашид-ад-Дин Жалайрын 10 овгийг жат, кункауыг, оймауыг, куркин, токрауыг, кумсауыг, нилкин, жулапкт, санкауыг гэжээ. Жалайр овгийнхон Төв Азийн өзбек, казах, монгол гэх мэт ард түмний бүрэлдэхүүнд түүхээ үргэлжлүүлжээ. Тухайлбал, казахын Их жузийн 9 аймгийн нэг нь жалайр юм.

Керей (хэрэй) аймаг Хангай, Хэнтийн улс, Орхон, Туулаар оршин байжээ. Хэрэйд аймгийг В.В.Бартольд, Б.Я.Владимирцов гэх мэт эрдэмтэд монгол хэлтэн аймаг гэсэн бол Рашид-ад-Дин, Абулгази-Бахадурхан, Х.Ховорс, С.Аманжолов гэх мэт эрдэмтэд түрэг аймаг гэжээ. Хэрэйд аймгийн 8-р зуунд нутаглаж байсан газрын талаар “Найман аймаг баруун талаараа Эрчис мөрний саваар нутагтай Канлы нартай, хойг талаараа киргисүүдтэй, зүүн талдаа Туулын хөндий, Орхон голын урсгалын дунд хэсэг, Онгийн саваар нутагтай, мэргэдтэй хөрш байсан” гэжээ.²⁴ “Ляо Алтан улсын үед Орхон гол болон Туул голын урсгалын дунд хэсгээр нүүдэллэн малжиж байсан түрэгийн нэгэн бүлгийг керей (хэрэйд) гэдэг” ба “керей аймаг нь уулаас ханглис (ханлы) аймгийн нэг бүлэг байжээ” гэж Д.Содном бичжээ.²⁵ 13-р зуунаас өмнө керейт, жырхын, хонхайд, сакайд, тумAUD, албат, тунхайд, киркун гэдэг 8 аймаг байжээ. Керей аймгийн гарал үүслийн талаар түрэг, монгол гэсэн хоёр санал байдаг ч, Керей аймаг бол Орхоны түрэгийн гол хэсгийн үлдэгдэл байсан нь батлагддаг. Хэрэйдийг Чингис хаан эзэлж, улмаар тэд Чингисийн цэргийн бүрэлдэхүүнд Дундад Азид, дараа нь Бат хааны цэргийн бүрэлдэхүүнд Европ хүрэв. Ийнхүү их том улс төрийн үйл явдлыг туулж өнгөрүүлсэн хэрэйдүүд, асар их өргөн нутагт тархаж, олон ард түмний бүрэлдэхүүнд ул мөрөө үлдээсэн байна. Тэд монгол овгууд, өзбекийн Кенегес аймгийн (абаклы, ашамайлы) Карахалпакийн хонгирад аймгийн - ашамайлы, крымийн татар, башкурт, казахын Дунд Жузийн Керей аймаг, Бага Жузийн керейт овгийг бүрдүүлжээ.

Найман 12-р зуунд Алтай Хангайн хоорондох нутгийг нутаглаж байв. Огузийн 24 аймгийн 8 нь найман болно.²⁶ Найман аймгийг 12-р

зууны эцэст Ининг Билгэ хаан захирч нэг хэсгийг нь Бай-Буха (Таян хаан), нөгөө хэсгийг Буйраг хаан (ах дүү хоёр) захирав. 12-р зууны үед Алтай, Элүй Сирас, Хөх-Ирдыш, Хара-Ирдыш, Хархорин, Алтайн уулс, Хэмчигүүдийн голд нутаглаж байжээ. Найман нар Орхоны түрэгүүдийн баруун хэсгийн үлдэгдэл байсан юм. Чингис хаан монгол нутагт байсан угсаатнуудыг нэгтгэхэд Керей, Найман нар хамгийн соёлжсон, бичиг үсэг, хот сууринтай байжээ. 1204 онд найманууд Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн болов. Найман нар Алтай, Эрчист нутаглахаас гадна Алакөл, Балхаш, Долоон Ус, Есил, Сырдария хүртэл тархан суурьшив.

Монголын эзэнт гүрэн задарсны дараа найманы зарим хэсэг нь өзбек, каракалпак, башкурт, киргизийн гэх мэт бүрэлдэхүүнд оров. Казахын одоогийн хамгийн том аймаг нь найман юм.

Татар аймаг Халх гол, Буйрын орчим нутаглаж байв. Байгал нуурын зүүн өмнөд талаар оршиж байсан аймаг. Хятадын сурвалж бичигт 8-9-р зуунд татар аймаг Монголын хойт хэсэг, Амар мөрний дагуу, Манжуураар нүүдэллэн та-та, та-тань гэж нэрлэгдэж байжээ. 8-р зууны үеэс хойш бараг 260-аад жил хятад сударт татаруудыг –хар тэрэгт, цагаан татар, буйргууд, алухай, айргууд болон баруун, өмнөд, зүүн татар, ёсон татар гэх мэт нэрлэж байжээ. Хөх түрэгүүдийн үед татаруудыг отыз татар, (30 татар), тогыз-татар (9 татар) гэж нэрлэж байв. Чухамдаа татар нь түрэг аймаг болохоос шивээтэй төдий холбогдолгүй юм.

12-р зууны үед татарууд-бархуй татар, бархуй татар, камаша татар, нучи татар, цагаан татар, алчи татар, хэмээх 8 аймаг татар байв. МНГ-д цагаан татар, алчи татар, дутауыг татар, алухай татар, буйрууг татар гэжээ.

Рашид-ад-дин татаруудыг “7 түмэн өрхтэй” гээд “Tutuqliut” гэжээ. 732 онд босгосон Күлтегины хөшөөний бичээст татар гэж тэмдэглээд (татан) нэрлэжээ. 13-р зуунд Европт шилжин суурьшиж, 13-14-р зуунд Алтан ордны бүрэлдэхүүний евроазийн ард түмнүүдэд уусчээ.²⁷

Онгод аймаг нь дундад зуунд Монгол орон, хойт Хятад, Дундад Ази болон Иранд нутаглаж байв. Тэдний угсаа гарлын талаар эрдэмтэд харилцан адилгүй саналтай байдаг. Олон эрдэмтэд монгол угсаатан аймаг гэж үздэг бол (ургийн холбоо), С.А.Аманжолов, П.Поуха нар онгод аймгийн нэр зэргийг судлан үзээд түрэг хэлтэн аймаг байсан гэжээ. Онгод (10 аймаг) аймаг 7-р зуунаас тодорхой бөгөөд цагаан хэрмийн гадна байжээ. Онгодын дараагийн түүх нь Чингис хаантай шууд холбогдон өрнөжээ. Түүнээс хойш 200 жилийн туршид онгод нар Дундад Ази, Ираны цэрэг, төрийн хэрэгт ихээхэн чухал байр эзлэв. Харин сүүлд үл мэдэгдэх шалтгаанаар онгод аймаг Дундад Азийн ард түмнүүдэд уусчээ.

Хонгирал. Хиад аймгийн удам болно. Цагаан хэрмээс нааш нутаглаж байв. Тэд олхонуд, ихирэс, харанууд, кункмуд гэсэн салбартай байв. Тэд Чингисийн дундад Азид хийсэн дайнд оролцон, нилээд хэсэг нь Дундад Ази болон Казахстанд үлдэн нутаглав. Тэд үүнээс хойш

Дашти-Кипчагийн зүүн гар болж, Төмрийн угсааны эсрэг тэмцэлд Абулхайр хааныг дэмжив. Тэгээд Хонгирадууд Казахстан болон Дундад Азийн түрэг хэлтэн аймгуудтай холилдон казах, өзбек, каракалпак, киргизийн бүрэлдэхүүнд оров.

Ийнхүү Монгол оронд байсан олон овог аймаг нь нэгэн улс гүрний дотор багтаж, тэдний хоорондын харилцаа улам нягтран өөр хоорондоо холилдохоос гадна, Евроазийн ард түмэнтэй холилдох болов. Ингэснээр евроазийн олон хэлний овог аймгуудын хуучин байрлал хувиран, урьдын улс аймгууд бие даасан нэгж байхаа больж, Чингисийн эзэнт гүрний нутаг дэвсгэрт шинэ угсаатан үүсэн бий болох шинэ шинэ голомтууд үүсэж, тэдгээрийн дотоод улс төр, эдийн засаг, хэл соёлын зэрэгцээ хөгжил явагдсанаар Төв Азид олон угсаатан улс төрийн бүтцийн эхлэл тавигдав.²⁸

Хорезм улс. (Сартуул). Дундад Ази дахь эртний улс. Хорезмийн түүх 19-20-р зуунд нилээд судлагдсан. Тэнд МЭӨ 4-р зуунд томоохон төр улс байгуулав. 712 онд арабууд түрэмгийлэн эзэлж хорезмийн соёлыг устгав. Мамун ибн Мухаммед 995 онд Хорезмийг дахин нэгтгэж, түүний үе залгамжлагч Мамун 2 ибн Мамуны үед цэцэглэн хөгжив. Атсыз (1127-1156) түүний ач Аладин ибн аль Арсалан (1172-1200), түүний хүү Мухаммед 2-ын үед Хорезм улс хүчирхэгжжээ. 1220 онд Чингисийн цэрэг орсоноор Хорезм улс задарч, Алтан Ордон улсын бүрэлдэхүүнд оров. 14-р зуунд Хорезм дахин цэцэглэн, хүн ам нь түрэгжих явц дуусчээ. 1388 онд Төмөр Ургэнчийг сүйтгэж, Хорезмийг эзлэв. Төмөр ба Алтан Ордны хаадын хоорондох Хорезмийн төлөө тэмцэл 100 жилийн турш үргэлжлэв. 12-17-р зууны эцэс хүртэл Хорезмыг Өзбекийн угсааныхан дараа нь Өзбекийн хонгирад овгийн цэргийн жанжид захирав. 1920 онд Зөвлөлт Хорезм Ардын Бүгд Найрамдах Улс байгуулагдлав.²⁹

Төв Азийн эртний болон дундад эртний овог, аймгуудын гарвал, үүсэл, дараах үргэлжлэл, нутаг дэвсгэр, бүрэлдэхүүн, нүүдэл суудал гэх мэт талаархи эрдэмтдийн санал бодлын зөрчил, мэдээллийн зөрчлөөс зөвхөн ганц аргаар этносыг бүрдүүлсэн угсаатны компонентүүдийг, угсаатны нутаг дэвсгэрийг хөшүүн сургааль байдлаар биш, амьд түүхэн үзэгдэл, өөрчлөлтийн хувьд, хөдөлгөөнд авч үзэх, хөрш зэргэлдээ ард түмнүүдийн түүхэн хувь заяатай харьцуулан, янз бүрийн угсаатны бүлгийн өөрийнхөө одоогийн, үндсэн нутагтаа, хэдийд, яаж хүрсэн гэх мэт зүйлийг нарийн судалснаар хүрч болох юм.

Эрдэм шинжилгээний утга зохиолд угсаатны (этнос) тухай дараах тодорхойлолт бүрэлдэн бий болжээ. Этнос гэдэг бол тодорхой нэг гадаад галбир, төрхийн нийтлэг шинж тэмдгүүд, тэрчлэн нилээд тогтвортой соёл болон хэлний шинж, зан авирын байдал хийгээд өөр үндэстэн ба арьстанд ижил төстэй биш болохоо ухаарсан хүмүүсийн хэсгийн түүхэн бүрэлдэн тогтсон нэгдэл, холбоо юм.

Л.Н.Гумилёвийн тодорхойлсноор: “Этнос-устойчивый естественно сложившийся коллектив людей, противопоставляющий себя всем прочим аналогичным коллективам и отличающийся своеобразным стереотипом поведения, который закономерно меняется в историческом времени”.³⁰

Ер нь угсаатны шатлал нь омог, овог, аймаг, угсаатны хэсэг, угсаатан, их угсаатан, угсаатан мандалаар дамжин антропомандал (хүн төрөлхтөн) болдог юм. Иймд аливаа угсаатны хөгжил нь нийт хүн төрөлхтөний оршин тогтнох зүй тогтолд тулгуурлах боловч тухайн угсаатны гарвал үүсэл, нутаг дэвсгэр, хөгжлийн мөчлөг, нийгэм-эдийн засгийн түвшин, этногенетик, этносоёлд нөлөөлөх дотоод, гадаад хүчин зүйл шууд нөлөөлдөг.

Харин хүмүүст тэднийг өөр овог аймгийн ялган харьцуулах дундын нийтлэг хэсэг бүрэлдэн тогтохын тулд, тэдгээр хүмүүс урт удаан хугацаанд, бүр бүрэлдэх эхний үе шатанд байлаа ч гэсэн нэг-нэгтэйгээ нийлэн нэгдэж, садан хүмүүс шиг хамт амьдрах хэрэгтэй болно. Эдгээр нь бүгдэд нь нийтлэг нэг нутагт аж төрж, оршин тогтнох нөхцөлд л бий болох үзэгдэл юм.

Төв Азийн нутаг дэвсгэрт аж төрсөөр ирсэн, аж төрдөг угсаатан үндэстэнгүүд болон угсаатны нутаг дэвсгэр нь түүхийн урт удаан үйл явцын үр дүнд бүрэлдэн тогтсон байна. Харин эдгээр угсаатан, үндэстэнгүүдийн угсааны бүрэлдэхүүн нь Төв Азийн хил хязгаар доторхи (зарим тохиолдолд хил залгаа нутгуудаас) ард түмнүүдийг бүрдүүлж байсан сак, хүннү, усун, кангюй, хөх түрэг, түргеш, карлук, огуз, кимак, кипчаг, хамаг монгол, найман, керей, хонгирад, жалайр, дулат, кидан, мэргид, тува, уйгур гэх мэт Төв Азийн уугуул овог аймгийн хойшис билээ.

Төв Азийн ертөнцөд янз бүрийн угсаатан, үндэстэн бүрэлдэн тогтож хөгжихөд үндэс болсон этногенетикийн үзэгдлийн үндсийг нэн эрт үеэс, эртний нийгэм задарч, угсаатны хөгжил бие даан явах болсон чанарын өөрчлөлт гарсан тэр үеэс хайх ёстой юм. Эдгээр хөгжлийн үйл явц нь анхандаа-автохондар эхэлж, дараагаар нь Төв Азийн өргөн уудам нутаг дахь угсаатны хөгжлийн өөрчлөлттэй шууд хамааралтай явагджээ. Угсаатны түүхийн алгуур хөдлөх явц нь дийлэнх тохиолдолд Төв Азийн хил хязгаар эртний болон дундад зууны хамгийн том улс төрийн үйл явдлууд, түүнээс гадна дайн байлдаанууд болон ард түмнүүдийн нүүдэл суудал, овог, аймгийн холбоо, түрүү үеийн феодалын төр улсууд үүсэн бий болж, задран мөхөх явдлаар тодорхойлогдоно.

Ерөнхийдөө авч үзвэл, Төв Азийн хил хязгаар дахь этногенетикийн үзэгдлийн хөгжлийг судлаачид дараах байдалтай авч үздэг. Антропологийн баримтаас авч үзэхэд, угсаатны хөгжлийн явцад тус бүс нутагт урт удаан хугацаанд оршин суугчдын галбир төрх, монголойд, европойд болон монголойд - европойд холимог төрхтөн хадгалагджээ.

Хэлний хувьд үндсэндээ Алтай болон Энэтхэг-Европын зарим хэл оршиж иржээ. Тухайлбал, эртний иран хэлт аймгууд түрэг хэлтэнтэй ижилжээ.

Төв Азид сак, хүннү, усун, түргеш, хөх түрэг, карлук, огуз, кимаг, кипчаг, хамаг монгол, найман, керей, хонгирад, жалайр, дулат, кидан, мэргид, тува, уйгур хүннү гүрэн, сяньби, кидан, тобо, хар кидан, уйгур, хиргис, кидан гүрэн, монголын эзэнт гүрэн зэрэг төр улс, овог, аймгуудын холбоонд өөрийн доторхи угсаатны үйл явцын хөгжилд шинээр бий болсон тогтвортой нийгэм-улс төрийн хэлбэрүүд өөрийнхөө нөлөөгөө хүргэх болов. Өөрийн нутаг дэвсгэрийн хамгаалах эрх ашиг нь тэдгээр их угсаатан-улс төрийн холбоонуудын доторхи угсаатны хэсгүүдийг нэгдэн нийлэхэд нэмэр болов.

Төв Азийн уугуул оршин суугч угсаатнуудын талаархи мэдээлэл МЭӨ I мянган жилд хамаарагдана. Харин нилээд тодорхой зүйл МЭ VII зууны эхнээс байх бөгөөд ялангуяа, хөрш зэргэлдээ суурьшмал угсаатнуудын сурвалж бичиг болон өөрсдийнхөө орхон-енисейн бичээс, “Монголын нууц товчоо” зэрэг дурсгалуудад тодорхой баримт мэдээ уламжлагдан иржээ. Өрнө, дорнодахины судлаачдын ачаар Төв Азийн оршин суугчдын тухай шинжлэх ухааны олон зуун бүтээл хэвлэгджээ. Угсаатны хөгжил нь өөрийн зүй тогтолтой байгалийн нийгмийн хувьслын явцад ирээдүйн хөгжлийн хэд хэдэн хувилбараас сонгох субъект болдог. Аливаа угсаатан түүхээ өөрөө нь бүтээдэг боловч энэ нь сонголтын хүрээнд хязгаарлагдаж, мөн түүнд үндэслэгддэг байна. Угсаатны амьдралын нөхцөл өөрчлөгдөх тутам түүнийг зохицуулдаг зүй тогтол мөн адил өөр болдог ажээ.

- Угсаатны хөгжил нь тайван, тогтвортой хөдөлгөөнд, гадаад дотоод хүчин зүйл эн тэнцүү үйлчлэх үед /статидинамик/ аливаа угсаатан тод томруун харагдаж, өөрийн дүр төрх ул мөрөө нь үлдээнэ.

- Угсаатны хөгжил нь тайван бус, тогтворгүй хөдөлгөөнд /социодинамик/ орсноор дүр төрх, ул мөр нь бүдгэрэн, заримдаа шинэ нийтлэг бүрэлдэх голомт үүсгэн буюу ямар нэгэн угсаатанд юм уу, угсаатны хэсэгт ууссан шингэж байжээ.

- Угсаатны тогтолцооны хувьсал дахь удамшлын механизм, хувьсал, шалгарал /социогенетик/ нь тэрний хөгжлийн гол хандлагыг тодорхойлон иржээ. Төв Азийн өнөөгийн угсаатнууд түүхийн урт удаан хугацаанд өмнөх удамшлыг залган, тэдний хойшис болохын хамтаар тодорхой хувьсалд өөртөн, байгаль-нийгмийн олон шалгарлыг даван туулж, биосферын үй түмэн зүй тогтоолын илрэн хэрэгжсэн үзэгдлийн нэгэн хэсэг байсаар ирэв.

Төв Азийн уугуул угсаатны түүх, түүний өсөлтийн динамик нь маш нарийн төвөгтэй, жигд биш, тахир муруй, түүхэн дэглэмийн бэрхшээлтэйг харж болох юм. Сүүлийн мянгаад жилд Төв Азид олон томоохон түүхэн явдал болж өнгөрсөн нь өнөөгийн угсаатнуудын газар нутаг, улс төр, соёл, менталитетэд нь гүн ул мөрөө үлдсэн байна. Төв Азийн уугуул угсаатнууд хүчирхэгжиж, нүүдлийн соёл иргэншил хүрээ тэлж байсан ч үе байсан, харь угсаатны түрэмгийлэлд тал талаас өртөн,

нутаг дэвсгэр хүн ам, төрийн тусгаар тогтнолоо алдаж байсан ч үе байсан, дахин сэргээж байсан зэрэг түүхийг туулан өнгөрүүлж байв. Гол нь хамгийн бэрх цагт устан сөнөсөн угсаатнууд байсан болов ч ихэнх нь янз янзын цаг үед өөрсдийнхээ амь амьдралаа тэсэн хамгаалж ирлээ. Төв Азид бурхан, исламын шашин тархсанаар эрэлхэг уугуул угсаатнууд дайчин чанараа алдаж, дуулгавартай болов.

Төв Азийн уугуул угсаатнуудын хүн амь зүйн түүх нь өөдрөг байгаагүй бөгөөд эдийн засаг- нийгэм, шинжлэх ухааны хоцрогдлын хамтаар хөрш Хятад, Оросын их гүрнүүдийн түргэмийлэлд өртөв. Үржил шимт нутгаа алдан, хүн амын байгалийн өсөлт нь саарав. Өнгөрсөн зууны коммунист хувьсгалууд, түүний хор уршиг Төв Азийн угсаатнуудад хамгийн хүнд тусаж, их угсаатнуудад хүчээр уусан сөнөх даваанд шууд тулж ирсэн угсаатны тоо олон болов. Хаант Оросын үеийн түрэмгийлэл, харгислал, 1916-1939 онуудад болсон геноцид, 1941-1945 оны дайн, зөвлөлтийн ард түмэн гэгч хуурамч суртал нэвтрүүлэг нь ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Төв Азийн угсаатнуудыг сүйрлийн байдал руу түлхэв.

Манж Чин улсын түрэмгийлэл, харгислал, Хятадад бараг өнгөрсөн зууны туршид геноцид нь тус улсын хятад биш үндэстний ард түмний аж төрөх, оршин тогтноход бодит аюулыг тулгав.

Эдгээрийн үр дүнд тэдгээр улсын бүрэлдэхүүнд байсан Төв Азийн олон уугуул угсаатан хөөрхийлэлтэй байдалд оров. Тэд өөрсдийн угсаатны бүтэц, газар нутаг, хүн ам ахуй, угсаатны хосгүй үнэт зүйлсээ алдан, өндөр уул руу шахагдан, соёл иргэншлийн хөгжлөөс хол хаягдав. Дорно зүгээс хүн ам нь хамгийн их хятадууд, өмнө талаас хүн ам нь Хятадаас үл дутах Энэтхэг, баруун хойноос хүн ам нь цөөн бус славянынхан, баруун талаас исламын их ертөнц Төв Азийн уугуул угсаатныг хүрээлж байна. Дотоод Азийн уугуул угсаатнууд бараг бүгдээрээ өөрсдөөс нь арай илүү хөршүүдийн түрэмгийлэлд өртөн колончлагдаж байсан түүхтэй. Тэр нь бараг 100-300 жил үргэлжсэн байлаа. Энэ нь суугуул угсаатнуудын этноинтеграцийг саатуулав. Угсаатны эв нэгдлийг эвдэн, бүлгийг өөр угсаатан, үндэстэн, арьстанаар цоохорлон холимог болгов. Гэлээ ч тэдний этнобиологи, этносоёлын нийлэгжих явц явагдсаар байв. Энэ санаагаа баримтаар лавшруулан харуулж болох юм. Хүн төрөлхтөний түүхэнд хамгийн томоохон гэмт хэрэг Евразид үйлдэгдсэн байна. Энэ нь дэлхийн хоёр их дайн ч биш, экологийн каталкализм ч биш, их гүрний дээрэнгүй үзэл ч биш, хэдэн зуун сая хүнийг устгасан геноцид ч биш бөгөөд ХХ зууны хамгийн том гэмт хэрэг бол хэдэн зуун үндэстнийг бантан шиг хутган холилдуулсан явдал байв. Үүний үр дүнд Евразид хэдэн зуун үндэстэн, угсаатан устан алга болж, давтагдашгүй унаган соёл сөнөж, дэлхийн соёл-оюуны өнгө төрх гандав. Энэхүү хэмжээлшгүй гай зовлонгийн буурин дээр мянга

мянган жилийн туршид бүрэлдэн тогтсон унаган соёлоо алдан кимерийн түвшинд хүрсэн миллиардаар тоологдох үймээгчид, хэдэн зуун сая аль ч угсаатанд үл хамаарагчид үлдэн, жижиг нь устан сөнөв.

Энэхүү уусган шингэх нь харьяангуй том угсаатануудад ашигтай боллоо. Ийм үйл явдлыг хэт их үндэстнүүд өөрийн эрх ашигт зохицуулан, соёл-оюун санааны уусган шингээх бодлогыг төрийн улс төр-үзэл сурталын зэвсэг хийдэг нь хэвийн үзэгдэл болсон харагдана. XXI зуун Төв Азийн уугуул угсаатнуудын сэргэн мандалын зуун болох төлөв бий болов.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Народы Сибири, М.-Л. 1956, Народы Средный Азий и Казахстана, т.1-2, М., 1963-1964. Народы Восточный Азии М.-Л., 1965., Народы Передный Азии М., 1957
2. Библиография работ по Монголии т,т 1-ҮШ. УБ, 1992. Ж.Батсуурь. Наследственный полиморфизм геногеография народнаслеление Монголии М., 1986, Л.Дашням, Д.Цэвээндорж, Н.Уртнасан, Монгол нутагт дахь түүх, соёлын дурсгалууд УБ. 2000 Монгол Улсын түүх. Тэргүүн боть УБ. 2003.х.183-240
3. Казахстаны түүх., боть.1 А., 1996. х.158-244, Григорьев В.В., О скифском народе саках. СПб.1871. Артаманов М.И, Сокровища саков. М.1973. Древние авторы о Средней Азии / в. до.н.э-Ш.в.н.э/ под. Ред.Л.В.Баженова.Таш., 1940. “Эртний сак, хүннү, хуны соёл” /КСЭ.т.2.А., 1973, Б.98-101/ Монголын түүх. Тэргүүн боть. 2003.х.183-246.
4. Казахстан түүх. боть 1, А., 1996. б.245-264. М.Хурметхан Төв Азийн эртний хаадын товч цадиг УБ., 2002
5. Г.Сүхбаатар Монголын эртний түүх судлал. Боть.1 УБ., 2000. т.156. Л.Н.Гумилев. Хүннү. М., 1960
6. Казахстан түүх. Боть, 1.А., 1996. б.245-272
7. Мөн тэнд., б.272-299
8. Г.Сүхбаатар. Сяньби. УБ., 1971. Монгол Улсын түүх. Тэргүүн боть УБ. 2003. х.246-288
9. Бартольд В.В.Очерк истории Семиречия, Соч., т. 2, ч.1 М, 1963. Бичурин Н.Я, Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена, т-1, М.-Л., 1950. Монгол Улсын түүх. Тэргүүн боть УБ., 2003. х.288-313. Г.Сүхбаатар. Монгол Нирун. УБ., 1992.
10. Малов.С.Е.Памятники древнетюркский письменности. Тексты и исследования М., -Л, 1951. Бичурин Н.Я. Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена. т.1-3, М., -Л, 1950-1953. Кляшторный С.Г. Древнетюркские рунические памятники как источник по истории Средней Азии.

- М., Гумилев Л.Н. Древние тюрки М.,1967. Н.Сэр-Оджав. Эртний түрэгүүд /6-8 зуун/ УБ., 1970
11. Орхонские надписи Кюль-Тегин, Билыге-каган, Тонькук. Семей. 2001
 12. Агаджанов С.Г. Очерки истории огузов и туркмен Средней Азии IX-XIII вв., Аш., 1969.
 13. Левшин.В.А., Кауфман.Х.Ф., Дяканов.И.М., О древней согдийской письменности Бухары”, “Восточных древней историй”, 1959., №1
 14. Монгол улсын түүх. Тэргүүн боть., УБ 2003, х,360-681
 15. Г.Сүхбаатар Сяньби УБ.,1971.х.64
 16. Кипчак.КСЭ.т.7,А,1975.,т.101-105.
 17. Карлук..КСЭ.т.7.А., 1975, т.520-521 Бартольд.В.В. Соч., т.2.,ч.1.М,1963 Шаниязов К, Узеки-карлуки.Таш., 1964
 18. Бартольд В.В. Соч.т.5 М., 1968. Кумеков.Б.Е. Государство Кимаков IX-XI.в.в по арабским источникам, А-А., 1972
 19. Монголын нууц товчоо.УБ,1976.
 20. Х.Нямбуу. Монгол угсаатан зүй. Удиртгал. УБ 1992. х.51
 21. Монгол улсын түүх. Дэд боть.УБ.,2003.т.44
 22. Х.Нямбуу Монгол угсаатан зүй. Удиртгал УБ, 1992.т.57.
 23. Рашид ад-дин. Сборник летописей,т.1.кн 2,М.,-Л., 1952. Бабурнама., 1958, История Казахской ССР. т.2,А.,1979.с.45
 24. Д.Содном Дундад улсын түүхэн дэхь аймаг угсаатны товч түүх. Хөх хот. 1987. х.142
 25. Мөн тэнд
 26. Абулгазы Бахадурхан. Роднсловное древо тюрков, Казань. 1891. Аристов Н.А.Заметки об этническом составе тюркских племен и народностей и сведения об их численности СПб. 1896. Муханов М.С.,Этнический состав расселение казахов Среднего жуза,А-А., 1974. Амажолов С.Вопросы диалектологии и истории казакского языка,А-А, 1959. Козин С.А. Сокращенное сказание, М.,-Л,1941.
 27. Хамитов.К.Таврих хамса. Казан., 1911, Маргулан А, Найман. В.св. Казахи, Л., 1930 Викторова Л.Л,К.восросу о найманской теорий происхождения монгольского литературного языка и письменности |ХП-ХШ.в.в| Уч.Зап ЛГУ. Серия Востоковеденических наук.в. 12 №305 с.137-55
 28. Происхождения казанских татар, Казань.,1948. Вопросы этногенеза тюркоязычных народов Средного Поволжья. сб.ст,Казань.1971.
 29. Бартольд В.В.,Туркестан в эпоху монгольского нашествия., ч 2. СПб. 1900 Веселовский Н.И. Очерк историко-географических сведений о Хивинском ханстве от древнейших времени до настоящего, СПб, 1876. Толстов С.П. Древнии Хорезм М., 1948
 30. Л.Н Гумилев. Этногенез и биосфера Земли Л., 1990.,с.,135.